

БАТЛАВ
САНГИЙН САЙД



Б.ЖАВХЛАН

БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙД



С.АМАРСАЙХАН

БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН
ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД

Мурасаг

Ч.ХҮРЭЛБААТАР

БАТЛАВ
ГАДААД ХАРИЛЦААНЫ
САЙД



Б.БАТЦЭЦЭГ

БАТЛАВ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Б.ЭНХБАЯР

**"ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АГААРААС АВРАХ АНГИД НЭМЭЛТ
СУРГАЛТ ЯВУУЛАХ ТӨСӨЛ"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН
САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл,
шаардлага

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэл, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн санал, дүгнэлт, Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хамтарсан хуралдааны санал, дүгнэлт болон Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 10 дүгээр сарын 05-ны өдрийн 162 дугаар захирамжийг үндэслэн "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрт Сангийн сайд Б.Жавхлан 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан.

"Онцгой байдлын еренхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах тесел"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтад заасны дагуу гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн еренхий нехцэлийн талаарх олон улсын гэрээ тул Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах шаардлагатай юм.

Хоёр.Хууль тогтоомжийн зорилго, еренхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн тесел нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд "Онцгой байдлын еренхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах тесел"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

"Онцгой байдлын еренхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах тесел"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн аливаа сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд Онцгой байдлын еренхий газрын аврах ажиллагааны мэргэжилтний мэргэжлийн үр чадварыг сайжруулан, онцгой байдлын үеийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Дөрөв.Хууль тогтоомжийн тесел Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн теслийг Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай, Хууль тогтоомжийн тухай болон бусад хууль тогтоомжид нийцүүлэх бөгөөд хуулийн теселтэй уялдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль байхгүй болно.